



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/694

Есөнбулаг

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Нээлттэй Алтай" хөтөлбөр, өрх бүрт өсөлт, иргэн бүрт орлого арга хэмжээний хүрээнд шинээр гэр бүл болсон залуу малчдыг малжуулахад орон нутгийн хөгжлийн санд батлагдсан 240.000.000 (хоёр зуун дөчин сая) төгрөгийг зарцуулах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т олгосугай.

2.Өрх тус бүрийг 50 толгой эм ямаагаар малжуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР